



НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2012 оны 05 сарын 01 өдөр

Дугаар

В/09

Улаанбаатар хот

Үрийн төмс худалдан авах тухай

Монгол Улсын Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн сайдын баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3 дугаар зүйлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2012 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төслийн жагсаалт, Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын даргын “Нийслэлийн ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар газар тариалан эрхлүүлэх хөтөлбөр”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, санхүүжүүлэх гэрээг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгино Хайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд хэрэгжиж буй “Нийслэлийн ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар газар тариалан эрхлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд 53 га бүхий талбайд тариалах 125 тонн үрийн төмсийг худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулахыг хөтөлбөрийн агрономч /Ж.Сүрэнжав/-д хариуцуулсугай.


2. Үрийн төмс худалдан авахад шаардагдах 93,750,000 /ерэн гурван сая долоон зуун тавин мянган/ төгрөгийг “Нийслэлийн ажилгүй иргэдийг бүлгийн зохион байгуулалттайгаар газар тариалан эрхлүүлэх хөтөлбөр”-өөс гаргахыг нягтлан бодогч /О.Одхүү/-д зөвшөөрсүгэй.

3. Үрийн төмс худалдан авах комиссыг хавсралтаар баталсугай.

ДАРГА



Г. БАТСАЙХАН



Нийслэлийн Хөдөлмөрийн газрын даргын 2012 оны 04 сарын 01-ны өдрийн тушаалын хавсралт

ҮРИЙН ТӨМС ХУДАЛДАН АВАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Ж.Сүрэнжав
Гишүүд	Г.Ганзориг
	Я.Эрдэнэ-Очир